

# ШАРГАЛЖУУТ

эрүүл мэнд  
амралтын цогцолбор

ШАРГАЛЖУУТ РАШААН СУВИЛАЛ ХХК-ИЙН  
2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ

/РЕГИСТРИЙН ДУГААР: 2550792/

Төлөвлөгөө боловсруулсан:

Шаргалжуут рашаан сувилал ХХК-н

Гүйцэтгэх захирал.....

/Т.Төвшин/

Байгаль орчны мэргэжилтэн .....

*Б.Оюунжаргал*

/Б. Оюунжаргал/

2024 он

## ТОВЧИЛСОН ҮГС

БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОХШХ	Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
БОНЕҮ	Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ
БОННҮ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
БОХХ	Байгаль орчны хөндлөнгийн хяналт
БХ ЗДХ	Баянхонгор аймаг
ОБГ	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
НӨ	Онцгой байлдын газар
НӨ	Нөлөөлөлд Өртөх
ШРС	Шаргалжуут рашаан сувилал

## АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
1.1 Дэд бүтэц:	5
1.2 Хүчин чадал:	5
1.3 Эмчилгээ үйлчилгээ:	5
1.4 Шаргалжуутын рашаан орд:	6
1.5 Зочид буудлын үйлчилгээ:	7
1.6 Хоол зоогийн үйлчилгээ:	8
1.7 Нэмэлт үйлчилгээ:	8
1.8 Уур Амьсгал	8
1.9 Геологийн тогтоц	8
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	9
2.1 Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн онцлог	9
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ ТОВЧ ТОРХОЙЛОЛТ.....	12
3.1 Төслийн болошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг тодорхойлох аргагүй.....	12
3.2 Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үр дагавар, эрчим.....	13
3.3 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл.....	16
3.4 Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал.....	17
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ..... ЗОРИЛТ	18
4.1 БОМТ 2025 зорилго, зорилт	18
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	20
5.1 Усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй нөлөөлөл	20
5.2 Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	23
5.3 Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	24
6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ	27
8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	28
9. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	31
10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	34
11. БОМТ-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ.....	36
12. ДҮГНЭЛТ	37

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Шаргалжуут рашаан сувилал нь анх 1954 онд Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын нутагт байрлах Шаргалжуутын халуун рашааныг түшиглэн байгуулагдсан. Байгуулагдсан цагаасаа өнөөг хүртэл 60 гаруй жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж жилд 7500-8000 орчим хүн хүлээн авч эмчилгээ сувилгаа, хоол зоог, зочид буудал, нэмэлт үйлчилгээ зэрэг бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлдэг Улсын үйлчилгээтэй Магадлан итгэмжлэгдсэн байгалийн эмчилгээний цогцолбор бүхий рашаан сувилал юм.

### 1.1 Дэд бүтэц:

Шаргалжуут рашаан сувилал нь Улаанбаатар хотоос 630 км, Баянхонгор аймгийн төвөөс 60 км зайд, Эрдэнэцогт сумын нутагт Шаргалжуут голын эрэг дагуу далайн төвшнөөс дээш 2150 метрт өргөгдсөн Хангайн нурууны өвөр хэсэгт Шаргалжуутын хөндийд байрладаг. Шаргалжуутын бүлэг рашаан нь 40-96 градус бүхий 300 гаруй булагтай, 10 га талбайг хамран урсдаг Монголын хамгийн том рашаан орд юм.

### 1.2 Хүчин чадал:

Шаргалжуут рашаан сувилал нь зуны улиралд нэг ээлжиндээ 600 хүн, өвлийн ээлжиндээ 200 хүн хүлээн авч эмчилгээ сувилгаа хийх хүчин чадалтай. Нэг үйлчлүүлэгч дунджаар 7 хоног амарч сувилуулахаар ирдэг бөгөөд эмчилгээний хугацаанд 4-5 удаа рашаан эмчилгээ, 3-4 удаа шавар эмчилгээ хийдэг. Рашаан сувилал нь 60-120 ажилтантай, 365 хоног ажилладаг.

Сувиллын үйл ажиллагаа нь улирлын онцлогоос хамааран хавар намрын улиралд хүчин чадлынхаа 70 орчим хувийг, зуны улиралд 100 хувь, өвлийн улиралд 50 хувийг ашигладаг.

### 1.3 Эмчилгээ үйлчилгээ:

Эмчийн үзлэгийн 6 кабинетаар нарийн мэргэжлийн олон жил ажилласан дадлага туршлагатай эмч нар сувилуулагч бүрийг үзэж тусгайлан эмчилгээний хөтөлбөр гаргаж хөтөлбөрийн дагуу эмчилгээ сувилгааны 23 тасагаар Рашаан эмчилгээ Шавар эмчилгээ, Уламжлалт эмчилгээ, Физик эмчилгээ зэргийг хослуулсан 20 төрлийн эмчилгээ сувилгаа хийдэг.

Эмчилгээний төрөл

- |   |                                |
|---|--------------------------------|
| - Рашаан уух                                | - Рашааны ууранд суух          |
| - Рашаан ваннад орох                        | - Халуун шавар эмчилгээ        |
| - Рашаан утлага                             | - Замаг эмчилгээ               |
| - Халуун рашаанаар ороолт бигнүүр           | - Агаар эмчилгээ               |
| Рашаанаар цөс ходоод, гэдэс угаах           | - Халуун чулуун жин бигнүүр    |
| - Физик эмчилгээ                            | - Давсан агуй давсан зам       |
| - Аппарат эмчилгээ                          | Биеийн тамир, хөдөлгөөн заслын |
| - Уламжлалт эмчилгээ /зүү, төөнүүр/эмчилгээ |                                |
| - Татлага эмчилгээ                          | - Иог бясалгалын тайвшруулах   |
| - Бариа засал                               | эмчилгээ                       |
| - Фитнес                                    | - Эмэгтэйчүүдийн эмчилгээ      |

Манай сувилал харшил, астма ба амьсгалын замын эмгэгүүд, мэдрэлийн тогтолцооны эмгэгүүд, хүүхдийн ДЦП, элэг, цөс, хоол боловсруулах эрхтний эмгэг, бөөр давсаг, эмэгтэйчүүдийн өвчин, чихрийн шижин, үе мөчний эмгэг, арьсны эмгэгүүд гэх мэт олон төрлийн өвчин эмгэгтэй сувилуулагчдыг эмчилж сувилдаг. Эмчилгээний үр дүн эдгэрэлт, сайжралт 90-95%-тай байдаг. Эмчилгээгүй гэсэн олон өвчтөнг эмчилж эдгэрүүлсэн бодит түүх байдаг. Шаргалжуут рашаан сувилал нь эмчилгээний өндөр ач холбогдолтой олон төрлийн халуун, бүлээн рашаан, эмчилгээний шавар, замаг, рашааны уур зэргийг сэргээн засах орчин үеийн бальнеотехникийн олон төрлийн эмчилгээ, уламжлалт анагаах ухааны эмчилгээг иог болон эмчилгээний биеийн тамиртай хослуулан хэрэглэдэг учир эмчилгээний үр дүн сайтай байдаг. Энэ бүхний дүнд харшлын гаралтай эмгэгүүд, гуурсан хоолойн багтраа, үе мөчний хэрх өвчин, элэг, бөөрний архаг үрэвсэл, хүүхдийн саажилт, чихрийн шижин зэрэг өвчнүүдийг эмчлэхэд сонгомол эмчилгээ болж байгаа.

## 1.4 Шаргалжуутын рашаан орд:

Шаргалжуутын халуун рашааны орд газар нь 10 гаруй га талбайг хамарсан газрын гүнээс байгалийн жамаараа ундран урсдаг 60°-96°С-ийн халуунтай 300 гаруй рашаан булгаас тогтдог хоногт 5,0 сая литр (өвөл) - 7,0 сая литр (зун) халуун рашаан ундран урсаж гол руу ордог. Монгол орны байгалийн халуун ууртай ганц газар. Өвлийн -30°С хэмийн хүйтэнд ч ундран урсаж байдаг мөнхийн халуун рашаан юм. Өвөлдөө рашааны анагаах чанар хамгийн сайн байдаг. Шаргалжуутын 64 зүйлийн өвчнийг анагаах 108 төрлийн рашааны шинж чанар, бүтэц найрлага нь:

^ Уушигны рашаан	^ Хамрын	^Эр эм бэлгийн
^ Элэг цөсний рашаан	^ Чихний	^Ясны
^ Зүрхний рашаан	^ Хоолойн	^Улаан бөөм
^ Мэдрэл сэргээх рашаан	^ Өвдөг тохойн	^Цагаан бөөм
^ Оюун ухааны рашаан	^ Үе мөчний	^Хүрэн цоргот
^ Ходоодны хүчил ихдэх	^ Шүдний	^Даралтны
Үеийн	^ Хөхний	^Сахарын гэх мэт
^ Ходооны хүчил	^ Давсагны	^Хөлний
багадах үеийн	^ Хүйсний	^Нүдний
^ Нарийн бүдүүн	^ Харшлын	^Лхамын рашаан
гэдэсний	^ Эмэгтэйчүүдийн	^Бөөрний рашаан

Шаргалжуутын 300-аад рашаан булгууд нь зориулалт, шинж чанар, амт, халууны хэмжээгээрээ бүгд өөр бөгөөд өөр өөрийн чухал бүтэц найрлагаараа хоорондоо харилцан адилгүй байдаг.

Бүтэц найрлагаараа:

- Байгалийн идэвхжсэн устөрөгчөөр баялаг.
  - Хүхэр, давс, нүүрстөрөгч болон олон төрлийн эрдэс бодисыг агуулдаг.
  - 90 градусаас дээш халуунтай рашаануудад өвчин үүсгэгч нянгийн эсрэг бактери (Термофил) агуулагддаг.
  - Бүлээн, хүйтэн рашаануудын найрлагад байван, барагшун агуулагддаг.
- Кальцийн агууламж өндөр бүхий ЯС-ны рашаан
- Фторын агууламж өндөр бүхий ШҮД-ний рашаан
- Азотын агууламж өндөр бүхий ҮЕ МӨЧ-ний рашаан
- Ходоодны хүчилийг хэвийн хэмжээнд байлгадаг рашаан (РН 8,5-9,5)

Онцлог шинж чанараараа:

- Ясны рашаан нь бүхэл кальци гаргадаг.
- Хоолойн рашаан нь дуу авиагаар гардаг.
- Бүүвэйн рашаан
- Хөлний дүрс бүхий хадтай рашаан
- Хорхойтой хүйтэн рашаан зэрэг юм.

Дээрхи 300-аад рашаан булгуудыг шинж чанараар нь авч үзвэл:

- Хүйтэвтэр рашаанууд 23-30° градустай.
- Халуун бүлээн рашаанууд 30-45° градустай.
- Халуун рашаанууд 50-86° градустай.
- Буцлан оргилох рашаанууд нь 90-96° градустай буцалж гардаг ба рашааны ундаргын ихэнхийг эзэлдэг.

- Рашаан булгууд нь өөр өөр амт чанартай байдаг хүхэрлэг, гашуун, исгэлэн, амтгүй, давслаг, хосолмол гэх янз бүрийн амттай байдаг ч тунгалагаас тунгалаг рашаанууд.
- Рашаан булгуудад өөр өөр өнгийн замаг ургадаг, Улаан, Шаргал, Ногоон, Хар ногоон, хар халтар гээд янз бүрийн өнгийн замаг ургасан байдгаас рашаан булгууд өнгө өнгөөр алаглан урсаж байдаг.

Халуун рашааны нөлөөгөөр рашааны сав газар болон сувиллын орчинд харьцангуй дулаахан байдаг. Мөн 96<sup>0</sup>С халуун рашааныг сувиллын барилга байгууламжийн халаалалтад хэрэглэдэг. Ямар ч зуух, яндангүй агаарын бохирдолгүй 100 % цэвэр эко орчинтой сувилал юм.

### **1.5 Зочид буудлын үйлчилгээ:**

Манай байгууллага дулааны улиралд өдөрт 400 хүн, өвлийн улиралд 200 хүн хүлээн авч байрлуулах хүчин чадал бүхий 8 зэрэглэлийн өрөөний ангилал бүхий зочид буудалтай. Зочид буудлын ангилал

- Эко хаус цогцолбор
- Сойдон апартамент цогцолбор
- Төв байрны люкс өрөө
- 2 ортой энгийн өрөө
- 3-4 ортой энгийн өрөө
- Зуны байр
- Энгийн гэр, зочны гэр

Сойдон апартамент танилцуулга: Тус цогцолбор нь 2019 онд ашиглалтад бүрэн орсон. Орчин үеийн засал чимэглэл бүхий люкс зэрэглэлийн 30 өрөө бүхий зочид буудал, рашаан саун, иог фитнесийн тусгай тоног төхөөрөмжтэй заал, рашаан бассейн, зоогийн газар, амралтын талбай бүхий иж бүрэн цогцолбор юм.

Эко хаус танилцуулга: Цогцолбор нь 2015 онд ашиглалтад орсон нийт 3 ангилал бүхий 16 өрөөтэй зочид буудалтай, гаднаа усан ориглуур, амралтын талбай гардентай орчин үеийн засал чимэглэл бүхий цогцолбор.

Төв байрны люкс өрөө- Нийт 36м<sup>2</sup> талбайтай 2 өргөн ортой, ариун цэврийн өрөө, рашаан ваннтай, 1 тагттай бүх үйлчилгээндээ ойр гэр бүлээрээ байрлах боломжтой люкс зэрэглэлийн өрөө. Жилийн 4 улирлын турш үйлчлүүлэгч хүлээн авна.

2 ортой энгийн өрөө- Нийт 17м<sup>2</sup> талбайтай энгийн стандарт тохижилттой өрөөндөө 2 ортой, ариун цэврийн өрөөтэй, 1 тагттай бүх үйлчилгээндээ ойрхон байрлалтай. Жилийн 4 улирлын турш үйлчлүүлэгч хүлээн авна.

3-4 ортой энгийн өрөө- Өрөөндөө 3-4 ортой, давхардаа нийтийн 00 душтэй энгийн тохижилттой өрөөнүүд. Жилийн 4 улирлын турш үйлчлүүлэгч хүлээн авна.

Энгийн гэр, зочны гэр- 5 ханатай нэг гэрт 3-4 ортой гадаа нийтийн боловсон 00-той энгийн болон стандарт тохижилттой гэрүүд. Зөвхөн зуны улиралд үйлчлүүлэгч авах боломжтой.

### **1.6 Хоол зоогийн үйлчилгээ:**

Зоогийн газар: Одоогийн байдлаар 160 хүний суудалтай нийтийн заал, 60 хүний суудалтай заал, 100 хүний суудалтай ресторантай.

Хоол зоог: Нийтийн хоол болон захиалгат хоолны чиглэлээр ажиллаж байсан туршлагатай баг хамт олон Өдрийн 4 удаагийн хоол цай, сувилал эмчилгээний зориулалттай талх нарийн боов болон захиалгат хоолоор үйлчилдэг. Мөн эмчийн зааврын дагуу эмчилгээний хоол, үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу цагаан хоол хийж үйлчилдэг.

### **1.7 Нэмэлт үйлчилгээ:**

Амрагч үйлчлүүлэгчийн чөлөөт цагийг зугаатай, үр дүнтэй өнгөрүүлэх зорилгоор төлбөртэй болон төлбөргүй нэмэлт үйлчилгээ үзүүлдэг

- ^ Комунити клубээр дамжуулан гар урлал болон уран зургийн хичээл заадаг;
- ^ Теннис, бильярд, шатар, хөзөр тоглох өрөө байртай;
- ^ Сагс волейболын талбайтай;
- ^ Гадаа голын эрэг дээр амрах рашаан амралтын талбайтай;
- ^ Гадаа кино үзэх задгай театрттай;

^ Рашаан саун;

^ Фитнес, иогоор хичээллэх иж бүрэн тохижуулсан заалтай;

^ Рашаан ордоор танилцах, 96<sup>0</sup> буцалж буй рашаанд өндөг чанаж идэх аялал зохион байгуулдаг;

## **1.8 Цэвэрлэх байгууламж:**

Сувиллын үйл ажиллагаанаас гарсан ахуйн бохир усыг бохир усны хоолой, худгуудаар дамжуулан, өөрийн урсгалаар нь бохир усны санд хуримтлуулж, ахуйн том оврын хог хаягдлыг шүүж анхан шатны механик цэвэрлэгээ хийгээд 2-4 цаг тутамд сувиллаас 2.0 км орчим зайд байрлах бохир ус цэвэрлэх байгууламжинд (ЦБ) нийлүүлдэг байна. Энэ оны II улирлаас SBR технологийн шинэчлэл хийж хүчин чадалаа сайжруулах ажлаа эхлүүлээд байна. Биологийн цэвэрлэгээндээ олон улсын НТ технологийн Байгаль орчинд ээлтэй БиоЭко (Хими, хими технологийн хүрээлэнгийн Био-эко био бэлдмэл Вирус, бактерийн халдвараас урьдчилан сэргийлэх ариутгалын бэлдмэл, Ашигтай загварын гэрчилгээ №20- 00003273), бэлдмэлийг шинээр нэвтүүлэх, мөн цэвэрлэх байгууламжийн технологийн шинэчилэлийн ажлыг эхлүүлэх зорилгуудыг тавиад байна.

## **2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ**

### **2.1 Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн уур амьсгалын онцлог**

Хангайн нурууны өвөр талын эрс тэс уур амьсгалын шинжтэй. Гэвч рашааны орчим уур амьсгал нь бэсрэг бичил шинж бүхий өвөрмөц онцлог бүрэлдэн бий болдог. Нарны гийгүүлэл тал хээр газраас харьцангуй богино үргэлжилдэг, хур бороорхог сэрүүн зунтай, өвөл нь цасархаг, хавар хожуу эхэлж, намар эрт сэрүүсдэг.

Байгаль дээр олон тохиолдохгүй халуун рашааны нөлөөгөөр ялангуяа хүйтэн улиралд тэр орчиндоо бичил уур амьсгалын зөөлөвтөр чийглэг нөхцөлийг бий болгож өглөө орой цан хяруу олонтой тохиолддог. Рашаан орчимд өдрийн цагт хөндийгөөс уул өөд, шөнө уулнаас хөндий рүү, шөнийн хугацаанд үүрээр, өглөөгүүр рашааны гадаргууд босоо тархалт ихтэй /10-50м/ уур манан бөмбийж, орчны температур чийглэг дулаахан тааламжтай байдаг. Энэ бол эмчилгээний бэлэн нөөц төдийгүй хүний бие тайвширч, цусны даралт буурч, бие махбодь сэргээж, өвчин эмгэг илааршдаг хүчин зүйл болж өгдөг байна.

#### **Нарны цацраг**

Нарны цацрагийн тэнцэл III-X сард эсрэг, V-X сард эерэг 8.2-8.5 ккал/см<sup>2</sup> сар байдаг байна. Жилдээ 2800 цаг, өвлийн саруудад 190 цаг, V-III-саруудад 250 цаг тус тус нар гийгүүлж, боломжит хугацааныхаа 60% орчмыг эзэлнэ. Нэг өдөрт өвөл 6 цаг, зунд 8-9 цаг нар гийгүүлнэ.

#### **Агаарын даралт**

Жилийн дундаж агаарын даралт 608.6 мм мөнгөн усны баганын өндөртэй тэнцүү, үнэмлэхүй хамгийн бага 593 мм, үнэмлэхүй хамгийн их 634 мм хүрдэг. Өвлийн саруудад их 608-610 мм, зуны саруудад 606 мм орчим өөрчлөлт тун бага, хүний биед нэн тохиромжтой. Гэвч нэг хоногийн доторхи өөрчлөлт ихсэх нь хүний биед ялангуяа зүрх судас, даралт, сэтгэл мэдрэлийн эмгэгтэй хүмүүст ихээхэн нөлөөлдөг.

#### **Салхи**

Салхины зонхилох чиглэл жилийн дунджаар зүүн хойноос /33%/, баруунаас /24%/, баруун өмнөөс /16%/-ийн давтагдалтай байна. Өвлийн улиралд хойд, зүүн хойноос /73%/, зүүнээс /17%/, зүүн өмнө, баруун өмнөөс болон баруун хойноос бараг салхилдаггүй. Хавар IV сард зүүн хойд зүгийн салхины давтагдал эрс буурч, харин өвөл намуун тохиолдол зонхилно. Баруун өмнөөс баруун хойд чиглэлийн салхи ихсэж баруунаас /39%/-ын давтагдалтай байна. Зүүн өмнө, өмнө зүгээс салхилдаггүй. Хаврын салхины онцлог зун ч хадгалагддаг. VII сард баруун өмнө, баруунаас /28%/-ын давтагдалтай салхи зонхилно. Хөндийн дагуу уулын адаг бэлээс хөндийн дагуу зүүн хойд /21%/, баруун өмнө /28%/ чиглэлийн салхи тод илрэлтэй. Рашаан орчинд салхигүй байх давтагдал жилийн 47%-ийг эзэлнэ. Рашаан орчимд зонхилох чиглэлийн салхины хурд 4.4-4.7 м/с, цөөн давтагдалтай чиглэлийн 0.8\*1.2 м/с байдаг. Жилийн дундаж салхины хурд 2.5 м/с, хамгийн их нь 20 м/с хүрнэ.

#### **Хур тунадас**

Рашааны дулаан улиралд эмчилгээнд цаг уурын нөхцөлөөс шалтгаалан 25 хоногт шүүдэр унаж, 2 өдөр мөндөр цохиж, 43 өдөр зүс, шиврээ бороо орж, 15 хоногт аадар бороо өдөр аянга тохиолдоно. Тогтвортой цасан бүрхүүл X сарын 2,3-р 10 хоногийн орчим үүсч V сард арилдаг. Хүйтний 200 хоногт рашаан эмчилгээг эмчилгээний байранд хийх бололцоотой. Гэвч сувилуулагчид хүйтэн, салхи шуурга 10 хоногт нөлөөлөл ихтэй, цас орсон 27 хоногт эрс хүйтэрч даарах бээрэх, гам алдах болдог. Ялангуяа хүйтэн улирлын эхлэл, төгсгөлөөр рашааны орчинд мөстөлт үүсэж халтиргаа гулгаа үүсдэг. Мөн 100 хоног цан, хүүрэг ихээхэн үүсэж бас төдийлөн аятай байдаггүй. Хүйтний улиралд рашаан дотор уур манан тогтож байдаг нь эмчилгээний ихээхэн өгөөж болдог.

### **2.2 Геологийн тогтоц**

Шаргалжуутын халуун рашааны хойт, зүүн хэсгээр тектоник хагарлаар залгагдсан нарийн зурвас



маягаар тархсан, гадаргууд ил гарч ирсэн нь ажиглагдахаас гадна хэсэг газар боржингийн массив дотор жижиг ксенолит маягаар тархсан байна. Энэ тунамал хурдас нь ногоовтор ба хар ногоон өнгөтэй янз бүрийн ширхэгтэй элсэн чулуулагаас тогтох ба 0.3-0.5 метрийн, хааяа 30-50 метр хүртэл зузаантай алевролит, аргиллит, алевро-элсэн чулууны үеүүдийг агуулсан байна.

Шаргалжуутын голын хөндийн доод хэсгээр тархсан элсэн чулуунууд нь ан цавшилд нилээд орсон, бутрамтгай, хар ногоовтор саарал өнгөтэй байх ба хааяа бор хүрэн өнгийн хүчиллэг найрлагатай туфын жижиг үеийг агуулсан байна. Районы дунд хэсгээр Шаргалжуутын голын хөндийг хөндлөн баруунаас зүүн тийш чиглэн тектоник хагарлын хил заагийн дагуу тогтсон тунамал чулуулаг нь эндоконтактын хувиралд маш ихээр автагдаж, бүдгэвтэр саарал өнгийн талстлаг занарт шилжсэн байна. Энэ чулуулаг нь босоо чиглэлийн ан цавшилд маш их орсноос гадна биотит ба цахиурын ислээр баяжигдсан жижиг үенцэрүүд /прослойка/ ээлж дараалан тогтсон нь маш тодорхой ажиглагдана. Хангайн Синклинорд тархсан девоны настай энэ тунамал хурдас нь Түйн голын сав дагуу болон түүний зүүн салаа цутгалан Шаргалжуутын хөндийн савын доод хэсгээр үлэмж ихээр тархсан ба Эрдэнэцогт сумаас баруун урагш 15 км-т 8р-ийн чулуужсан үлдэгдэл олсон нь А.П.Юрины тодорхойлсноор живетскийн ярусын цаг үед хамаарагдаж байна /А.К.Уфлянд/. Энэ свитын ерөнхий зузаан нь 1500-2200 м гэж тогтоогдсон байна.

### 2.3 Геоморфологи

Манай орон геоморфологийн мужлалтын хувьд Сибирийн геоморфологийн их муж, Төв Азийн геоморфологийн их муж гэсэн хоёр их мужид хуваагддаг ба дотор нь 13 муж, 39 дэд мужид ялгагддаг. Үүнээс Баянхонгор сум /хот/ орчим болон Эрдэнэцогт сум нь Төв Азийн геоморфологийн их мужийн Хангайн мужийн Хангайн дэд мужид хамаарагддаг (БНМАУ-ын Үндэсний атлас.,1990). Геоморфологийн хэв шинжийн хувьд нутгийн ихэнх хэсгээр Уулт- Атриат өргөгдөлийн элэгдэл тектоникийн гадарга бүхий хэрчигдэл ихтэй нуруу тархах бөгөөд нутгийн төв хэсгээр өндөр уул бүхий дунд зэрэг хэрчигдэлтэй нуруу, тэгшрэлийн гадарга, нутгийн баруун болон зүүн хэсгээр хөндийн ёроолын, татмын болон нам дэнжийн голын хурдаст тал, зүүн өмнөд хэсгээр мөсөн голын үйлдлээр үүссэн тал, галт уулын 9 хотгор гүдгэр бүхий хөндийн бялхмал бэгэлцэг зэрэг нь хослон оршдог онцлогтой.

### 2.4 Гадаргын ус

Хангай, Хэнтийн уулсын тогтолцоогоор дайран өнгөрдөг усны хагалбар нь Монгол орны сүлжээг 3 ай савд хуваадаг. Шаргалжуут рашаан сувиллын газар нь ус зүйн хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтана Энэ ай савд Хангайн нурууны гол усан хагалбараас эх авсан Түйн, Таацын голууд орох ба эдгээр голуудын гольдрол нь хэвийн байдалдаа 25-80 м, үерлэсэн үедээ 150-200 м болж хэлбэлзэх ба гүн нь 0.5-1.5 м, харгиа боргиотой хэсэгт 0.2-0.3 м, хадан хавцалын хоорондын цүнхэлүүдэд 2.5-3.0 м хүрдэг. Төслийн талбайн ойр орших зарим голуудыг авч үзвэл:

**Асгат гол:** Энэхүү гол нь Эрдэнэцогт сумын нутгийн зүүн хэсэгт Ногоон нурууны зүүн урд хажуугаас эх авч зүүн урагшаа урсан Шаргалжуутын голын зүүн гарт цутгадаг.

**Шаргалжуут гол:** Төслийн талбай нь Шаргалжуут голын дагуу байршдаг. Шаргалжуут гол Хангайн нурууны өврөөс эх авч баруун урагшаа 70 орчим км урсаад Түйн голын зүүн гарт цутгана. Тус голд Өвгөнжаргалант, Угалзын голууд баруун гар талаас нь цутгадаг.

### 2.5 Хөрс

Шаргалжуут рашааны сувиллын газар нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Төв Азийн Говийн их мужийн цайвар хүрэн хөрсний дэд бүсийн Нууруудын хөндийн тойрогт хамаарагдана. Уг шаргалжуутын рашаан нь Шаргалжуутын голын эрэг, голруу түрж орсон уулын урд энгэр нутгаар тархсан тул энэ хавийн хөрсөн бүрхэвчинд уулын хар хүрэн, аллювын нугын хөрс тархсан байна.

### 2.6 Ургамлан нөмрөг

Их муж: Голарктик

Дэд муж: Эртний газар дундын тэнгис

Муж: Иран-Туран

Дэд муж: Төв Азийн хээр цөл

Хошуу: Монголын хээр цөл

Дэд хошуу: Умард говийн цөлөрхөг хээр

Тойрог: **Олон нууруудын хөндийн цөлөрхөг хээр**

Хангайн нуруу болон Говь-Алтай, Монгол-Алтайн нурууны өмнөд хэсгийн шувтаргын уулын дунд оршдог бараг тэгшивтэр талархаг гадаргатай нарийвтар боловч тавиун хотгор хоолойг энд хамруулна. Хөндийн урт нь 500 гаруй, өргөн нь 150 км хүрнэ. Энэ хөндийд Орог, Бөөнцагаан, Таацын цагаан, Улаан нуур хэмээх 4 томоохон нуур бий. Эдгээр нуурууд нь Хангайн нууруудаас эх авдаг Байдраг, Таац, Онон, Түйн голуудын усаар тэтгэгдэнэ.

## 2.7 Амьтны аймаг

Шаргалжуут рашаан сувилал нь Баянхонгор аймгийн Баянхонгор сумын нутагт орших ба тус нутаг нь Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалаар (А.Г.Банниковынхаар, 1954) Говийн дэд муж, Говь-Алтайн уулын тойрог, Алтайн өмнөх Говийн тойргийн заагт хамаарна. Тус тойрогт жижиг хөхтөнөөс говийн алга даага, дагуур огдой, шар чичүүл, дагуур үхэр огдой, хөх шишнүүхэй, сохор огдоно, урт сүүлт зусаг, дэлдэн зараа, туулай зэрэг байдаг бол мах идэшт амьтдаас цагаан үен, хотны үен, хярс, үнэг чоно амьтдын амьдрах орчин болдог онцлогтой.

## 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### а. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үр дагавар, эрчим

Рашаан ордыг хүний хөлийн нөлөөнөөс хамгаалсан модон зам 2 км урт 140 см өргөн, тавих ажил, шугам хоолойн шинэчилэх 2021 онд бүрэн шинэчилж дуусгасан, явган хүний гүүрний шинэчлэлийн ажил, рашааны ванны шинэчлэлийн ажил, ногоон байгууламжийн агротехникийн үйл ажиллагааг тогтмол хийж гүйцэтгэх, шугам хоолой солих үед техник үйл ажиллагаанд өртсөн газрыг биологийн нөхөн сэргээлт хийх буюу зүлэгжүүлэх, түүх соёлын биет болон биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх зэрэг ажлуудын хүрээнд “сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ”-г төлөвлөхдөө барилгын ажлын үед байгаль орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлон тэдгээрээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээнүүдийг төлөвлөв.

Шаргалжуут рашаан сувиллын үйл ажиллагаа болон сувиллын ойролцоо амьдарч буй айл өрхүүдийн үйл ажиллагаанаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд тодорхой хэмжээний сөрөг нөлөөлөл үзүүлнэ гэж үзсэн.

Хүснэгт 1. Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагддаг	Рогино хугацаатай	Урт хугацаатай	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага
<i>1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт</i>										
Газрын доорхи урсацын өөрчлөлт	x				x		x		x	
Газрын доорхи усны чанарын өөрчлөлт		x	x		x					x
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x				x		x		x	
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x		x	
Геологийн тогтоцын өөрчлөлт		x			x		x		x	
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт		x			x					x
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		x	x							x
<i>2. Байгалийн нөөц ашиглалт</i>										
Газрын гадаргын нөөц ашиглалт	x				x	x			x	

Бэлчээрийн байдал	x				x	x		x			
Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x	x			
<b>3. Байгаль орчны өөрчлөлт</b>											
<b>Байгаль орчны үзүүлэлт</b>	<b>Шууд</b>	<b>Шууд бус</b>	<b>Өөрөө зохицуулалт</b>	<b>Хугацаатай</b>	<b>Богино</b>	<b>Урт хугацаатай</b>	<b>Бүлэж нөлөөлөх</b>	<b>Бүлэггүй нөлөөлөх</b>	<b>Хүчтэй</b>	<b>Дунд зэрэг</b>	<b>Бага</b>
Ундны усны чанар, хэмжээ	x					x		x		x	
Агаарын бохирдол		x		x							x
Хөрсний эвдрэл, бохирдол	x					x		x	x		
Дуу чимээ, шуугианы нөлөө	x			x				x			x
<b>4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор</b>											
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	x					x		x		x	
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x					x		x		x	
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх		x									x
<b>5. Нийгэмд үзүүлэх нөлөө</b>											
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	x					x		x		x	
Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх	x					x				x	
Хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх	x					x		x		x	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	x					x		x		x	
<b>6. Эдийн засаг, байгаль орчин</b>											
Татварын орлого өөрчлөгдөх	x					x				x	
Орон нутгийн орлого нэмэгдэх	x					x		x		x	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x					x				x	
Ажлын байр нэмэгдэх	x					x				x	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x					x		x			x
<b>7. Бусад нөлөөлөл</b>											
Шороон зам харилцаа, амрагчдын болон түүхий эд тээвэрлэлтийн хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	x					x		x	x		
Хог хаягдлаар хүрээлэн буй орчин бохирдох	x			x						x	
Бохир ус цэвэршүүлэх бага оврын тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа доголсноос цэвэршүүлээгүй бохир усаар хөрс, гадаргын болон гүний ус бохирдох	x			x			x		x		
<b>Дүн</b>	<b>23</b>	<b>6</b>	<b>2</b>	<b>4</b>	<b>23</b>	<b>3</b>	<b>16</b>	<b>5</b>	<b>17</b>	<b>7</b>	

Нийт 29-н нөлөөлөл байгаагаас 23 нь буюу 79,3% нь шууд нөлөөлөлд хамаарч байна. Учир нь байгалийн баялгийн /рашаан/ шууд ашиглан үйл ажиллагаагаа явуулж байгаа тул хөрс, ус, эдэлбэр газар, ургамлан бүрхэвчид шууд нөлөөлж байна. Харин гадаргын болон гүний усны чанар, найрлага, амьтны аймаг, агаарын чанарт шууд бусаар нөлөөлж байна. Нийт нөлөөллүүдийн 58,6% нь дунд зэргээр, 24,1% нь бага зэргийн эрчимтэй нөлөөлөхөөр байна.

## **б. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал**

Шаргалжуут рашаан сувиллын газрын Сойдон бүсийн бүтээн байгуулалтын болон бусад нэмэлт ажлууд нь (байгаль орчны асуудлын хувьд техноген үйлчлэлд автагдсан) нь байршилтай холбоотой. Байгаль орчинд нөлөөлөх 8 нэр бүхий гол нөлөөлөл байхгүй, харин 3 түвшинд үүссэн нөлөөллийг бууруулах дарааллыг тусгасан болно. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудалд “Гол нөлөөлөл байхгүй” дурдагдсан бүх үйл ажиллагаанууд бүртгэгдэв, Үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төсөөллийг багтаасан төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудалд “Гол нөлөөлөл байхгүй” Шаргалжуутын рашаан сувиллын газрын ид ачааллын үед гарах шуугианыг тогтоосон хэмжээнээс багасгах, Технологийн үйл ажиллагааны үед агаар, хөрс бохирдох, хатуу хог хаягдал гарах, их дуу чимээ гарах хүчин зүйлүүд орсон байна. Үр дагавар сайн нөхцөлд үйл ажиллагаа, ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, бохирдлын хяналтын сонгосон төхөөрөмж нь хир зэрэг зохимжтой гэж үнэлэгдлээ.

Барилга, байгууламжийн хийц, барихтай холбогдож гарах байгаль орчны асуудалд “Гол нөлөөлөл байхгүй” Барилга байгууламжийг барих үед усны булингар бий болох гэсэн нөхцөл тусгагдсан бол Барилга, байгууламж барьсны дараах хөрсний эвдрэл, элэгдэл нөхцөл нь дунд үнэлгээгээр үнэлэгдсэн бол Ажиллагсадын төрөл бүрийн аваар, осолд өртөх байдал, хортой нөхцөл, халдвартай өвчин гарах нөхцөл нь маш багаар үнэлэгдэв.

Төслийн хэрэгжих үеийн байгаль орчны асуудалд төслийн хэрэгжүүлэх үед агаар, улмаар хөрс, усанд эсрэгээр нөлөөлөх үнэлгээ нь дунд гэсэн үнэлгээгээр үнэлэгдсэн тул энэ асуудал дээр онцгой анхааран ажиллах шаардлагатай.

Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд /бодлогын чанартай асуудлууд/-д бүх нөхцөлүүд “Гол нөлөөлөл байхгүй” гэж үнэлэгдлээ.

## **4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО**

### **а. БОМТ 2025 зорилго, зорилт**

Монгол улсын байгаль орчны хамгааллын бодлогод нийцүүлэн 2020 оноос байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг (БОАЖЯ) Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-аар 2021 онд хийлгэж, тусгай зөвшөөрөл бүхий “Баялаг эко” ХХК БОННУ-г боловсруулж, тус ондоо БОАЖЯ-аар батлуулсан. Түүнчлэн 2021 оны Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээний нэмэлт тодотгон хүрээнд нийт 6 бүлэг ажил хамааруулсан. Төсөл хэрэгжүүлэгч байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд тусгасан дүгнэлт, 2021 оны БОННУ зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарч БОМТ 2025-онд доорх үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдэд ангилан авч үзсэн.

#### **Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд**

- Усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй нөлөөллийг хянах бууруулах талаар: Рашаан ордын ундаргын мониторинг хийх, механик болон органик мөн химийн бохирдлоос сэргийлэх, үйлчлүүлэгчдэд байгалийн нөөцийн зохистой хэрэглээний талаар хандлагыг өөрчлөх мэдлэг олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр голлон зорилт дэвшүүллээ.
- Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах чиглэлээр: Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ногоон байгууламж зам талбайн усалгааг тогтмолжуулж, агротехнологийн арчилгааг технологийн дагуу хэрэгжүүлэх, агаарын тоосжилтыг бууруулах, шатах тослох бодис агаарт дэгдэхээс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөв.
- Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах чиглэлээр: Хог хаягдлыг төрөлжүүлэн ангилах, багасгах, дахиварт хүргэх бүртгэх, хэмжих ажлыг тогтмол хэрэгжүүлэхээр зорилт тавьсан болно. Мөн агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь хөрсийг

хамгаалах арга хэмжээг дэмжин хэрэгжих юм.

### **Орчны тохижилт нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд**

- Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, одоо байгаа модны суулгацуудыг арчлах, тордох, сувилалын орчинд явганаар зорчих замыг шинээр барьж, үйлчлүүлэгчид тав тухтай байх нөгөө талаас хөрсний элэгдлээс сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх.

### **Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд**

- Олон жилийн түүхтэй Шаргалжуут рашааны түүхийн өв болсон дээр үед ордог байсан эртний 7 ванныг хамгаалж хүмүүст таниулах.
- Байгалийн нөөцийг зүй зохистой хэрэглэх, хамгаалах талаар сувилуулагчид болон дамжин өнгөрөх амрагчдад мэдээлэл түгээх.

### **Хог хаягдлын менежментийн чиглэлээр**

- Хог хаягдлын менежментийг сайжруулах, хог хаягдлыг дахин боловсруулах, орон нутгийн хогийн цэгийг түрэх ажлуудыг төлөвлөж.

2025 онд БОМТ- г хэрэгжүүлэхэд нийт **236,326,720** төгрөг төсөвлөгдөв. БОМТ 2025 оны төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах талаар мөрдөж ажиллах баримт бичиг болон авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хуваарь, холбогдох журам, заавар, аргачлал, үр дүнгүүдийг тусгасан.

БОМТ- г хэрэгжүүлэхэд зарцуулах нэгдсэн төсвийг хүснэгтэнд оруулав.

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

### 5.1 Усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй нөлөөлөл

#### Хүснэгт 3. Усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй нөлөөлөл

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал,	Тоо хэмжээ	Нийт зардал,	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хүний хөл хөдөлгөөнөөр Рашаан булгийн эх бохирдох	Рашаан орд газарт халуун рашаан хооронд явсан явган хүний модон замыг гүйцээх	Рашаан орд газар	м	70,000	400	28,000,000	3 сар	<ul style="list-style-type: none"> <li>• Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам,</li> <li>• Рашаан зохистой ашиглах, хамгаалах журам</li> <li>• Усны тухай хууль</li> </ul>
2		Рашааны эрүүл ахуйн бүсийн хашааг шинэчлэх	Рашаан орд газар	м	88,000	1000	88,000,000	5-7 сар	
3	Цэвэрлэх байгууламжийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж хөрсөн бүрхэвч, усан орчин бохирдох	Цэвэрлэх байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хангах, хаягдал усны даланг өндөрлөх	Цэвэрлэх байгууламж	м <sup>3</sup>	23,809	210	5,000,000	5 сар	
4	Рашааны undаргын судалгаа хийх	Рашааны undаргын мониторинг хийх	Рашаан орд	Үйл ажиллагааны зардлаар					
5	Рашааны эх undарга бохирдох	Рашаан орд дээрх рашаан цуглуулах савыг солих	Рашаан орд	ш	2,000,000	30-50 тн	2,000,000	3 сар	
6		Ашиглагдахаа больсон рашаан ордын бетон хийцийг нурааж цэвэрлэх	Рашаан орд	м <sup>2</sup>	21,600	25	540,000	9 сар	
7		Рашаан орд дээр байрлах утлаганы хэсгийг тогтмол цэвэрлэх	Рашаан орд	удаа	Үйл ажиллагааны зардлаар			7 хоног тутам	
8	Рашааны эх undарга бохирдох	Лхам рашааны тохижилтыг ажлын зургийн дагуу хийх	Лхам рашаан	м	330,000	30	10,000,000	5 сар	
9	Үерийн аюул	Үерийн ус хуримтлуулах сан, үерийн сувгийн судалгаа хийх	Рашаан орд	Үйл ажиллагааны зардлаар					
10	Шаврын нөөц багасах	Шаврыг нөхөн төлжүүлэх талбайг томруулах, төлжүүлсэн шаврыг дахин ашиглах	Эмнэлэг	Үйл ажиллагааны зардлаар					
<b>Нийт:</b>							<b>133,540,000</b>		

## 5.2 Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

### Хүснэгт 4. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1		Тоосжилтыг бууруулж цэвэрлэгдсэн хаягдал усаар төслийн талбайн замыг тогтмол услах	Төслийн талбай	ширхэг	30,000	90	2,700,000	6-9 сард	MNS 4227:2002 "Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө" MNS 6063:2010 "Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ"
2	Машин, техникийн хөдөлгөөнөөр агаарт тоос, тоосонцор үүсэх	Орчны тоосжилтоос сэргийлэн хурд сааруулагч нэмж хийх	Төслийн талбай	ширхэг	100,000	3	300,000	5 сард	
3		Барилгын дээвэрт борооны усны хаялга хийж борооны ус хуримтлуулж зам талбайн усалгаанд ашиглах	Төслийн талбай	м	100,000	100	10,000,000	6-9 сард	
4	Хүрээлэн буй орчинд хүчилтөрөгчөөр амьсгалдаг бүх амьд организмд нөлөөлөх	Агаарт шатах тослох материалын ууршилт гаргахгүй байх, техникийн засвар үйлчилгээний чанарт байнга хяналт тавьж, дутагдлыг арилгуулах, техникийн хяналтын үзлэг оношлогоонд хугацаанд нь хамруулах	Сувиллын газар болон хүрээлэн буй орчин	Үйл ажиллагааны зардалд тусгасан				Жилийн турш	
5									
							<b>Нийт:</b>	<b>13,000,000</b>	

### 5.3 Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

Хүснэгт 5. Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж (мян.төг.)	Баримтлах эрх зүйн баримт бичиг
3	Машин, техникийн хөдөлгөөнөөр хөрс талхлагдах	Авто зогсоолд тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Автомашины зогсоол		Үйл ажиллагааны зардал			3 сард	MNS 3297-1991, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм
4	Хөрс бохирдох	Бохирын худгийн кольцог шинэчлэх	Төслийн талбайд	ш	200,000	20	4,000,000	6 сар	
							<b>Нийт</b>	<b>4,000,000</b>	



## 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БОННУ-ний тайланд тусгагдсан болон “Тэрбум мод” төслийн хүрээнд 2023- 2024 онд шинэс, нарс, гацуур, голт бор, гиналын агч, үхрийн нүд, чацаргана нэр төрлийн 287 ширхэг модыг суулгацаар тарьж ургуулсан. 2025 онд нийт 3000 м2 талбайд ногоон байгууламж төлөвлөж байгаа бөгөөд үүнд 130 ш хайлаас мод тарьж 2000 м2 талбайг зүлэгжүүлэх зэрэг ажлыг төлөвлөөний дагуу хийнэ.

**Хүснэгт 6.** Ногоон байгууламж байгуулах зүлэг тарихад шаардагдах зардлын үнийн задаргаа

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг.
1.	Төслийн талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Зүлэгжүүлэлт	Талхлагдсан талбайд зүлэгжүүлэлт хийх	м2	440	2000	880,000	6 дугаар сараас зүлэгжүүлэлтийг хийх	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07-р сарын 30-ны өдрийн А/301 дүгээр тушаал. “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага” MNS 5918:2008 стандартын дагуу  MNS 5916-2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт”, MNS 5914:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт MNS 3297-1991, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм
2.	Зүлэгжүүлэлтийн усалгаа арчилгаа	Арготехник ийн арчилгаа	Төслийн талбайд	м2	Үйл ажиллагааны зардал	1050	Арчилгаа үйлчилгээ тогтмол явагдана	5-10 дугаар сард	
3.	Төслийн талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Цэцгийн мандал тарих	Төслийн талбайд	м2	300	500	150,000	5 сар	
4.		Хайлаас мод тарих	<b>Төслийн талбайд</b>	<b>ш</b>	<b>15340</b>	<b>130</b>	<b>2,000,000</b>	5 сар	
5.	Модны арчилгаа, бордоо таналт тайралт	Арготехник ийн арчилгаа	Төслийн талбайд	ш	25,000	50	1,250,000	4 сар	
6.	Мод тарьсан талбайн хашаа хайсыг сайжруулах	Хашаа хайсыг шинэчлэн мал орхооргүй болгох	Төслийн талбайд	м	20,000	300	6,000,000	4 сар	
7.	Хүний хөлийн шууд нөлөө рашаан ордын хэвийн орчинг алдагдуулахаас сэргийлэх	Рашаан ордын орох хэсэг, утлаганы хэсэгт газрын зураг тавих	Рашаан орд	ш	200,000	2	400,000	4 сар	
		Утлаганы хэсэгт гэрэл байршуулах	Рашаан орд	ш	50,000	1	50,000	3 сар	

8.	Явган хүний гүүр шинэчлэх	Явган хүний гүүр шинэчлэх	Рашаан орд болон төслийн талбайг холбосон	м	8,000,000	25	40,000,000	5 сар	MNS 5916-2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт”, MNS 5914:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт MNS 3297-1991, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм
9.	Рашаан ордын хогийн савыг шинэчлэх	Хогийн сав шинэчлэх	Рашаан орд	ш	80,000	6	480,000	4 сар	
<b>Нийт:</b>							<b>51,210,000</b>		

## 7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Төсөл хэрэгжүүлэгч аливаа аж ахуйн нэгж, байгууллага МУ-ын Соёлын өвийн тухай хуульд заасны дагуу түүх, соёлын өвийг авран хамгаалах үүрэгтэй байдаг. “Соёлын өвийг хамгаалах тухай” 17 дугаар зүйлд заасны дагуу “газрын хэвлийг ашиглах явцад түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл ашиглагч нь ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ” Хэрэв энэхүү заалтыг зөрчсөн тохиолдолд 200.000- 250.000 төгрөгөөр торгож, үйл ажиллагаа, судалгаа шинжилгээ хийх, хувилан олшруулах, хуулбар хийх, хадгалалтыг зогсоох, хууль бусаар олсон орлогыг хураах арга хэмжээ авахаар заажээ.

### Хүснэгт 7. Түүх соёлын өвийг хамгаалах хэмжээ

№	Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг.
1.	Рашаан ордын эртний 7 ванн	Эртний 7 ванныг цэвэрлэж хамгаалан, мэдээллийн самбар байршуулах	Бүх амрагчид, ажиллагсад, эко аялал хийж буй дайран өнгөрөгсөд			Үйл ажиллагааны зардлаар	Шаргалжуут рашаан сувиллын газрын үйл ажиллагаа явагдаж байх бүхий л хугацаанд	“Соёлын өвийг хамгаалах тухай” Монгол улсын хуулийн 6 дугаар бүлгийн 17 дугаар зүйл.
2.	Рашаан орд	Рашаан орд руу орох хэсэгт хөтөч ажиллуулах	Рашаан орд				6-9 сард	

## 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Манай рашаан сувилал нь энэ онд хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд Байгаль орчны удирдлагын олон улсын тогтолцоо ISO 14001:2015 стандартыг нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна. Үүний хүрээнд орчны бохирдлоос сэргийлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, дахиварт өгөх, ил задгай хаяхгүй байх тусгай тэмдэглэгээ бүхий ангилах зориулттай хогийн савыг байрлуулах, хуваарьт цэвэрлэгээ хийх, хогоо ангилан сар бүр хоёрдагч түүхий эд авах цэгт тээвэрлэн хүргэх, мөн БХ аймгийн Баянхонгор сумын Шаргалжуутын 8 р багийн захиргаатай хамтран нийтийн хогийн цэгт тогтмол техноген үйл ажиллагаа явуулж цэгцлэх, мөн тус багийн эмнэлэгтэй Эмнэлэгийн хог хаягдлын гэрээг хийж ажиллах, хог хаягдлын бүртгэл хөтлөх, нийт ажиллагаадад хог хаягдлын ангилан ялгалт сэдэвт сургалтыг зохион байгуулаж ажиллахаар төлөвлөгөөндөө тусгалаа. **Мөн Баянхонгор аймгийн Байгаль аймгийн байгаль орчны газрын саналын дагуу хог хаягдлын цэгийн менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр тусгав.**

### Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг.
1.	Ахуйн, аюултай болон халдвартай хог хаягдал	Шаргалжуут тосгоны нийтийн хогийн цэгт зохион байгуулалтгүй хаясан хогийг багийн захиргаатай хамтран машин механизмаар түрэх	Бардангийн амын хогийн цэг	удаа	3,000,000	4	12,000,000	Улиралд 1	Хог хаягдлын тухай хууль; Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/349 дугаар тушаалын хавсралт. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл; MNS 5344 : 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага;
2.	Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Нийтийн их цэвэрлэгээг хийх	Төслийн талбайд	9га	Үйл ажиллагааны зардал			4-9 сард	
3.		Ангилсан хог хаягдлыг хэмжиж бүртгэх	Бүх алба бүх барилга байгууламж					Үйл ажиллагааны туршид	
4.		Хог хаягдлын талаар сургалт сурталчилгаа нийт ажилтан ажиллагсад	Сургалт мэдээлэл түгээх					5 сар	
5.		Хог хаягдлыг түр хадгалах цэгийг шинэчлэх	Аж ахуйн хашаа					3 сар	
6.		Дахивар хог хаягдлыг дахивар авах цэгт хүргэх	Төсөл гүйцэтгэх үйл ажиллагааны талбайн хэмжээнд	удаа				80,000	

7.	Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хоол үйлдвэрлэлийн явцад гарсан ногооны хаягдлыг ялзмагжуулж, хүлэмжний бордоо болгон ашиглах	Хоол үйлвэрлэл, хүлэмж	Үйл ажиллагааны зардал				Үйл ажиллагааны туршид
8.		Үйл ажиллагаанаас гарсан аюултай хог хаягдлыг аюултай хог хаягдлыг дахин боловсруулах байгууллагад хүргэж өгөх	Төслийн талбайд	удаа	300,000	2	600,000	Үйл ажиллагааны туршид
9.		Шил, ясны хаягдлыг буталж дахин ашиглах	Төслийн талбайд	ш	3,000,000	1	3,000,000	Үйл ажиллагааны туршид
10.		Шаргалжуут тосгоны иргэдээс дахивар цуглуулж Баянхонгор аймгийн дахивар авах цэгт тушаах	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардал				
11.		Гадаа талбайн хогийн савыг ангилдаг хогийн сав болгон төрөлжүүлэх	Төслийн талбайд	ш	80,000	14	1,120,000	3 сар
12.		Хоолны хаягдал хийх зориулалтын сав захиалж хогны уутны хэрэглээг багасгах	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардал				
13.		Шинэ ажилчдад хог хаягдал ангилах талаар өртөөчилсөн сургалт орох	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардал				
14.		“Ногоон хамгаалагч” компани ажлын үйл ажиллагааг сайжруулах	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардал				
15.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулах	Бардангийн амны хогийн цэгийг зөөж зайлуулах, нөхөн сэргээлтийн ажил хийх хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар боловсруулж батлуулах	Бардангийн амны хогийн цэг	Удаа	10,000,000	1	10,000,000	9 сар
							<b>Нийт</b>	<b>27,120,000</b>

MNS 5344 : 2011  
Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага;

## 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

### Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын байршил	Хугацаа, давтамж	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, мян.төг/жил	Тайлбар	Баримтлах стандарт ба арга, аргачлал
<b>Хөрсний шинжилгээ</b>						
Ялзмаг %, урвалын орчин рН, карбонат (P <sub>2</sub> O <sub>5</sub> ), механик бүрэлдэхүүн	Төслийн Цэвэрлэх байгууламжийн талбай, амрагчдын байрны ойролцоо	Жилд 1 удаа	70,0	240,0	3 дээж	MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам; MNS 3298-1991 Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд; MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
Хар тунгалаг (Pb), кадми (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni), натри (Na),			22,0	66,0	3 дээж	
			<b>Бүгд</b>	<b>306,000</b>		
<b>Усны шинжилгээ</b>						
Ундны усан дахь микробиологийн шинжилгээ	Худаг, гал тогоо	Жилд 1 удаа	75,400	150,800	2 дээж	MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS ISO 5667-10:2001 Байгаль орчин. Усны чанар. Дээжлэлт. 10-р хэсэг Хаягдал уснаас дээжлэлт хийх удирдамж
Ундны усны химийн шинжилгээ	Худаг	Жилд 1 удаа	135,000	135,000	1 дээж	
Шаргалжуут голын дагуу /хими, бакеторлоги/	Шаргалжуут гол	Зун ачааллын үед	135,000	405,000	3 дээж	
Цэвэрлэх байгууламжийн оролт гаралтын усны шинжилгээ	Цэвэрлэх байгууламж	Улиралд 1 удаа	677,380	2,709,520	8 дээж	
Рашааны эрүүл ахуйн шинжилгээ	Рашаан орд	7 р сард	75,400	75,400	1 дээж	
Дээж авах тээвэрлэх				250,000		
			<b>Бүгд</b>	<b>3,725,720</b>		
<b>Агаарын шинжилгээ</b>						
Агаар бохирдуулагч хий, азотын давхар исэл, хүхэрлэг хий	Машины зогсоол	Жилд 1 удаа	42,500	85,000	2 дээж	MNS3384:1982. Агаар мандал-Агаарын дээжлэлт шинжилгээ; MNS5365:2004 Агаарын чанарын ерөнхий асуудал. Нарийн ширхэгтэй гоосыг тодорхойлох арга; MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага;
Тоосжилт (PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub> ), гадаад болон дотоод дуу чимээ		Жилд 1 удаа	90,000	180,000	2 дээж	
			<b>Бүгд</b>	<b>4,296,720</b>		



## 11. БОМТ-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар төслийн нэгжийн байгаль орчны асуудал эрхэлсэн мэргэжилтэнд тайланг хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

**Хүснэгт 13.** БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

№	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцсан албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	Баянхонгор аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газарт	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан хүргүүлэх	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан	11 сард	Үйл ажиллагааны зардалд суусан	“Шаргалжуут рашаан сувилал” ХХК ийн байгаль орчны мэргэжилтэн	Шаргалжуут рашаан сувилалд
2	Шаргалжуут тосгоны иргэд, Шаргалжуут рашаан сувиллын ажилчид	Танилцуулга тавих	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан	12 сар	Үйл ажиллагааны зардалд суусан	Шаргалжуут рашаан сувилал” ХХК ийн байгаль орчны мэргэжилтэн	Шаргалжуут рашаан сувилалд

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны календарчилсан төлөвлөгөө гаргаж, БОХТ болон ОХШХ-ийг хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүн, тайланг компанийн удирдлага, байгаль орчныг хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагын өмнө хариуцан ажиллах үүрэг хүлээнэ.



## 12. ДҮГНЭЛТ

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа БОННУ ний тайланд тусгагдсан байгаль орчныг хамгаалах болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн боловсруулав. Байгаль орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийн бууруулах, арилгах заавар зөвлөмж, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа, давтамж, хөрөнгө зардлыг тусгасан болно.

2025 онд Усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулахад 133,540,000 , Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх,бууруулах,арилгах арга хэмжээнд 13,000,000 , Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээнд 4,000,000 , Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн арга хэмжээнд 51,210,000, Хог хаягдлын менежмент төлөвлөгөө 27,120,000.0, байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 4,296,720 , байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 6,160,000, **нийт 239,326,720** төгрөгийн хөрөнгө оруулалтыг үйл ажиллагаанд зарцуулахаар төсөвлөсөн.